

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн, үр ашиг

АУДИТЫН КОД: ТӨА-2021/109-18-ШТА-ГА

Зуунмод 2021 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Ахлах аудитор Л.Жаргалсайхан
Утас: 70273465 Цахим хаяг: jargalsaikhanl@audit.gov.mn
Аудитор Ч.Загдсүрэн
Утас: 70272287 Цахим хаяг: zagdsurench@audit.gov.mn
Аудитор Г.Сугармаа
Утас: 70273465 Цахим хаяг: sugarmaag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5-6
БҮЛЭГ А. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн	7
А.1 Сумдын хувьд ОНХС-г төлөвлөхөд иргэдийн санал авах ажил журмын дагуу хийгдэж байна. Аймгийн ОНХС-г төлөвлөхөд журамд заасан иргэдийн саналыг тусгах ажил огт хийгдэхгүй байна. 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын аймгийн ОНХС-г төлөвлөхтэй холбоотой заалтууд хэрэгжихгүй байна.....	7-10
А.2 Аймаг, сумдын ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хугацааг баримтлахгүй байх, зарим Үнэлгээний хорооны үйл ажиллагаа холбогдох журамд нийцэхгүй байх зөрчлүүд давтан гарсаар байна.....	10-14
А.3 Сумдын 2020 оны ОНХС-ийн хэрэгжилтийг авч үзвэл нийт батлагдсан ажлын 54.3 хувь нь огт хэрэгжээгүй байна.....	14-17
А.4 Хөрөнгө оруулалтаар шинээр бий болсон хөрөнгийг комиссын актаар хүлээж авч байгаа боловч ашиглагч эзэмшигч байгууллагын данс бүртгэлд тусгуулах ажил хийгдээгүй байна.....	17-18
БҮЛЭГ Б. Шилжих үлдэгдлийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт	18
Б.1 Хөрөнгө оруулалтын чанартай 44 арга хэмжээнээс 2020 онд шинээр хэрэгжих 33 арга хэмжээ нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны үндсэн чиглэлд тусгагдсан, 2 арга хэмжээ тусгаагдаагүй байна.....	18-20
Б.2 Худалдан авах ажиллагаатай холбоотой өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүд давтан гарсаар байна.....	20-23
Б.3 Шилжих үлдэгдлээр хэрэгжих 44 төсөл арга хэмжээнээс хөрөнгө оруулалтын чанартай 32 ажилд гэрээ байгуулснаас 27 ажил хугацаандаа бүрэн хэрэгжжээ.....	23-24
Б.4 Шилжих үлдэгдлээр хэрэгжих 4998.0 сая төгрөгийн 44 төсөл арга хэмжээ төлөвлөснөөс 136.6 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.....	24-25
Б.5 Он дамжин хэрэгжиж буй 1,390.5 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээнээс бусад хөрөнгө оруулалтын ажлуудыг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.....	25
БҮЛЭГ В. Замын сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн.....	25
В.1 Замын сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг холбогдох хууль, журмын хүрээнд төлөвлөж баталсан байна.....	25-26

В.2 Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих 10 ажлаас 7 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар гүйцэтгэгчийг шалгаруулж, 1 ажлыг зөвлөх үйлчилгээний тендерээр, 1 ажлыг шууд гэрээ байгуулсан, 1 ажил хэрэгжээгүй байна.....	26
В.3 Гэрээ байгуулсан ажлууд гэрээнд заагдсан хугацаанд хийгдэж комиссын актаар хүлээлгэн өгсөн байна.....	26
В.4 Замын сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн байна.	26
В.5 Замын сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдсэн ажлуудыг комиссын актаар хүлээж авсан хэдий ч эзэмшигч, ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгаагүй байна.....	26
БҮЛЭГ Г. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн.....	27
Г.1 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний жагсаалтад орсон нэг ажилд гүйцэтгэгч байгууллагыг нэр заан баталсан байна.....	27-28
Г.2 Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг авч үзвэл 3 ажлыг нээлттэй төсөл сонгон шалгаруулалтаар, 2 ажлыг харьцуулалтын аргаар, 3 ажлын худалдан авах, гэрээ байгуулах эрхийг сумдад шилжүүлж, 7 ажлыг шууд худалдан авалт хийсэн байна.....	28-29
Г.3 БОХНСАХЗ-аар хэрэгжих 19 төсөл арга хэмжээнээс хөрөнгө оруулалтын чанартай 9 ажилд гэрээ байгуулснаас 7 ажил хугацаандаа бүрэн хэрэгжиж 2 ажил хугацаандаа хэрэгжээгүй байна.....	29
Г.4 БОХНСАХЗ-аар хийгдэхээр төлөвлөсөн 19 төсөл арга хэмжээнээс 13 төсөл арга хэмжээ хэрэгжиж, 2 ажил хугацаандаа хэрэгжээгүй он дамжсан, 4 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.....	29-30
Г.5 Он дамжин хэрэгжиж буй 68.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээнээс бусад хөрөнгө оруулалтын ажлуудыг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.....	30
ДҮГНЭЛТ:	31
ЗӨВЛӨМЖ:	32
ХОЛБОГДОХ БАЙГУУЛАГЫН САНАЛ:	33-36
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР	37

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БОХНСАХЗ	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТОӨЗ	Тендерт оролцогчдод өгөх зөвлөмж
ТШӨХ	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
ТББ	Тендерийн баримт бичиг
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
БЗОСК	Барилга захиалагч, орон сууц корпорац
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын "Аудитын төлөвлөгөө батлах тухай" 2021 оны А/28 дугаар тушаал, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийлээ.

Аудитын зорилт

"Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн, үр ашиг"-д гүйцэтгэлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнтэй байсан эсэх
- Шилжих үлдэгдлийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнтэй байсан эсэх
- Замын сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнтэй байсан эсэх
- Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнтэй байсан эсэх

Аудитын хамарсан хүрээ

2020 онд аймгийн орон нутгийн төсвийн нийт 4 эх үүсвэрээс санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын 107 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт болон эдгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын хязгаарлалт

байхгүй

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Монгол улсын Төрийн аудитын стандарт, Аудит хийх журмыг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагын улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, захиалагч, гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэл, хяналт, санхүүжилтийн

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

тайлан, бусад шаардлагатай баримт материал, статистик судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдаж, аудитын менежер О.Амаржаргал чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Ч.Загдсүрэн, Г.Сугармаа нар гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2021 оны 4 дугаар сарын 20-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл гүйцэтгэлээ.

Хүндрэл бэрхшээл

Дэлхий дахиныг хамарсан covid 19 халдварт өвчин Төв аймагт нэмэгдсэнтэй холбогдуулан хөл хорио тогтоох, аудитад хамрагдагч байгууллагын холбогдох мэргэжилтэн тусгаарлалтад орох зэргээр шаардлагатай баримт мэдээллийг хугацаа хоцроож аудитын байгууллагад ирүүлэх, газар дээр нь хөрөнгө оруулалтын ажлыг үзэх зэрэг асуудалд хүндрэл бэрхшээл гарсан.

БҮЛЭГ А. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

А.1 Сумдын хувьд ОНХС-г төлөвлөхөд иргэдийн санал авах ажил журмын дагуу хийгдэж байна. Аймгийн ОНХС-г төлөвлөхөд журамд заасан иргэдийн саналыг тусгах ажил огт хийгдэхгүй байна. 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын аймгийн ОНХС-г төлөвлөхтэй холбоотой заалтууд хэрэгжихгүй байна.

Аймгийн төсвийг АИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан байна. ОНХС-ийн нийт эх үүсвэрийг 8,270.3 сая төгрөг, үүнээс ОНХНС-с 7,751.6 сая төгрөг, өмнөх оны үлдэгдэл 334,7 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 184.0 сая төгрөгөөр байхаар баталжээ. Аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 03 тоот тогтоолоор аймгийн төсөвт тодотгол хийж ОНХС-ийн нийт эх үүсвэрийг 7,125.6 сая төгрөг, үүнээс ОНХНС-с 7,125.6 сая төгрөг, өмнөх оны үлдэгдэл 56.3 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 184.0 сая төгрөгөөр баталсан байна.

ОНХНС-с хуваарилсан эх үүсвэрийг задаргаа

№	Эх үүсвэр	Эхний батлагдсан	Тодотголоор
1	АМНАТ	2255.9	2113.9
2	Дотоодын НӨАТ	1430.0	1180.2
3	Газрын тосны нөөц ашигласны төлбөр	416.2	195.4
4	Ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл	1497.6	1164.0
5	АМНАТ-Мега төслүүдээс хассан зөрүүний / 10 хувь /	1616.3	1842.3
6	ОУ-ын төсөл хөтөлбөрийн урамшуулал	368.5	368.5
7	ОУ-ын төсөл хөтөлбөрийн дэмжлэг	167.1	261.3
Нийт		7751.6	7125.6

/Эх сурвалж: МУ-ын Сангийн сайдын 2019 оны 12 сарын 27-ны өдрийн "Төсвийн хуваарь батлах тухай" 299 дүгээр тушаал/

Сумдын хувьд Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам", Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал", Сангийн сайдын 2016 оны 17 дугаар тушаалаар батлагдсан "Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос Орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг тооцох аргачлал"-д заасны дагуу тооцож ОНХС-ийн орлогыг баталж байна.

Аймгийн ИТХ-аар оны эхэнд сумдад 2,961.4 сая төгрөг баталсан бол тодотголоор 2,779.6 сая төгрөг болж, 181.8 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

№	Сумдын нэр	Эхний батлагдсан	Тодотголоор	Зөрүү
1	Алтанбулаг сум	81,599.6	74,472.1	7,127.5
2	Аргалант сум	27,635.9	26,104.3	1,531.6
3	Архуст сум	28,506.5	25,585.4	2,921.1
4	Батсүмбэр сум	99,548.3	94,032.4	5,515.9
5	Баян сум	357,902.1	348,197.0	9,705.0
6	Баяндалгэр сум	93,379.1	86,932.2	6,446.9
7	Баянжаргалан сум	157,813.0	128,764.4	29,048.6
8	Баян-Өнжүүл сум	88,760.9	78,754.8	10,006.2
9	Баянхангай сум	29,386.4	27,201.3	2,185.1
10	Баянцагаан сум	388,970.2	426,709.2	(37,739.0)
11	Баянцогт сум	52,382.0	46,314.0	6,067.9
12	Баянчандмань сум	75,238.3	74,471.7	766.6
13	Борнуур сум	82,308.8	76,239.7	6,069.1
14	Бүрэн сум	90,232.8	81,921.3	8,311.5
15	Дэлгэрхаан сум	79,576.4	69,193.5	10,382.9
16	Жаргалант сум	112,241.7	104,721.0	7,520.7
17	Заамар сум	290,392.8	244,350.5	46,042.3
18	Зуунмод сум	190,699.9	184,261.6	6,438.3
19	Лүн сум	69,081.8	62,535.2	6,546.6
20	Мөнгөнморьт сум	81,009.3	75,417.2	5,592.1
21	Өндөрширээт сум	63,906.0	58,163.6	5,742.3
22	Сүмбэр сум	37,568.7	34,212.1	3,356.6
23	Сэргэлэн сум	65,128.1	57,372.5	7,755.6
24	Угтаалцайдам сум	58,432.8	51,228.9	7,203.9
25	Цээл сум	53,196.6	50,110.9	3,085.6
26	Эрдэнэ сум	109,247.9	100,470.8	8,777.1
27	Эрдэнэсант сум	97,226.2	91,838.0	5,388.2
	Дүн	2,961,372.1	2,779,575.7	181,796.4

/Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 02 тоот тогтоол, 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 03 тоот тогтоол/

Тодотголоор Баянцагаан суманд 37.8 сая төгрөг нэмэгдэж, бусад бүх сумдад хуваарилагдсан мөнгө 0.8-46.0 сая төгрөгөөр хасагдсан байна.

Сумдын хувьд 2020 оны ОНХС-ийн төлөвлөлтийг 2019 онд хийхэд Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-г баримталж иргэд олон нийтийн оролцоог хангаж ажиллажээ.

Журмын 5.8-д “Баг, хорооны ИНХ-ын дарга дараагийн төсвийн жилд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэх, санал хураах хурлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10-т заасны дагуу хүчин төгөлдөр ирцтэйгээр 5 дугаар сард багтаан зохион байгуулна” гэж заасны дагуу сумууд 2019 оны 5 дугаар сард багийн ИНХ-р 2020 онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцүүлж, эрэмбэлсэн жагсаалт гаргажээ. Иргэдээс санал авах 3 арга журамд тусгагдсанаас бүлгийн ярилцлага, цахим хэлбэр болон техник, технологийн дэвшилтэт бусад арга хэлбэр ашиглагдаагүй зөвхөн санал асуулгын хуудас ашиглагдсан байна. Өмнөх жилүүдтэй харьцуулахад журмын хавсралт маягтуудыг бүрэн ашигласан, иргэдээс өгсөн саналыг эрэмбэлэхдээ тодорхой арга зүйг баримталсан, ИНХ-ын ирц тэмдэглэл, тогтоолыг журмын дагуу баримтжуулсан зэрэг дэвшилттэй ажил хийгдсэн байна.

Баянцагаан, Борнуур, Сэргэлэн зэрэг сумдын эрэмбэлсэн жагсаалт, багийн ИНХ-ын баримт материал аудитад хамрагдаагүй, бусад 24 сумдын 86 багийн 14221 иргэн санал асуулгад санал өгч 298 санал эрэмбэлснээс 152 санал сумын ИТХ-аар батлагдсан байна.

Аудитад хамрагдсан сумдын хувьд иргэдийн санал авч эрэмбэлэгдсэн ажлуудаас шаардлага хангасан ажлууд сумын ИТХ-аар батлагдсан байна. Харин Баян сумын хувьд Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг нийт 9 ажлыг эрэмбэлсэн боловч эрэмбэлэгдсэн ажлын жагсаалтад ороогүй 105.0 сая төгрөгийн 3 ажил ИТХ-аар батлагджээ.

Тодотгосон төсвөөр аймгийн хэмжээнд ОНХНС-аас 7,309.6 сая төгрөг авч эхний үлдэгдэл, бусад орлого, суурь зардал нэмэгдсэнээр 7,549.9 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, сумдад 2,779.6 сая төгрөг, аймгийн ОНХС-нд 4,306.2 сая төгрөг, суурь зардалд 464.2 сая төгрөг хуваарилан зарцуулахаар батлагдсан.

Төсвийн тодотгол баталсан тогтоолын 1 дүгээр хавсралтаар Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтыг 32 арга хэмжээг 4,122.2 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан. Бусад орлого буюу 184.0 сая төгрөгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх арга хэмжээг жагсаалтаар батлаагүй байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын аймаг, нийслэлийн түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх гэсэн 7-р бүлэгт дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан. Үүнд:

- Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулах,
- Урьдчилсан жагсаалт бэлтгэх,
- Иргэдийн санал авах,
- Сумын иргэд, ЗДТГ-с ирүүлсэн саналыг урьдчилсан жагсаалтад нэмж тусган, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг нэгтгэх,
- Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг 7 дугаар сард багтаан 2-оос доошгүй удаа зохион байгуулах,
- Аймаг, нийслэлийн Засаг дарга иргэд, иргэний нийгмийн байгууллагаас хамгийн олон санал авсан, ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулах,
- Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх зэрэг.

Аймгийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 420 тоот захирамжаар "аймгийн 2020 оны төсвийн төсөл боловсруулан, нэгтгэж хуулийн хугацаанд санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулах, хүргүүлэх зохион байгуулах" ажлын хэсгийг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулан 16 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

ОНХС-ийн журамд заасан иргэд олон нийтийг оролцоог хангах чиглэлээр ажлын хэсэг байгуулагдаагүй, аймгийн ОНХС-р хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө журамд заасан дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлээгүй байна. Өмнөх жилүүдэд ч аймгийн 2020 оны ОНХС-г төлөвлөхөд иргэдийн саналыг тусгаагүйгүй бөгөөд удаа дараа өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байна.

Зөвхөн сумдын ОНХС-г төлөвлөхөд иргэдийн саналыг авч, нийт санхүүжилтийн 57.0 хувийг эзэлж буй аймгийн ОНХС-г төлөвлөхөд иргэдийн саналыг авах, тусгах ажил огт хэрэгжихгүй өдий хүрчээ.

А.2 Аймаг, сумдын ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хугацааг баримтлахгүй байх, зарим Үнэлгээний хорооны үйл ажиллагаа холбогдох журамд нийцэхгүй байх зөрчлүүд давтан гарсаар байна.

Сумд 2020 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТ хуулийн хүрээнд цахимаар буюу tender.gov.mn сайтаар зохион байгуулсан байна. Сумдын хэмжээнд нийт 207 төсөл арга хэмжээ төлөвлөж, 115 худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас 188.7 сая төгрөгийн 3 ажлыг нээлттэй тендер, 1,183.3 сая төгрөгийн 47 ажлыг харьцуулалтын аргаар, 283.0 сая төгрөгийн 65 ажлыг шууд гэрээний аргаар хэрэгжүүлсэн байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд зарим зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Өндөрширээт сум, сумын төвийн хойд, урд худгийн тохижилт, цэвэршүүлэх төхөөрөмж тавих, цахим системд нэвтрүүлэх 25.8 сая төгрөгийн ажилд хяналтын зураг төсөвгүй тендер зарлагдаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹ болон Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.1.3²-д заасныг зөрчсөн.
- Угтаалцайдам сум ахмадын өргөө барих 46.1 сая төгрөгийн өртөгтэй ажилд 2020 онд ОНХС-с 9.0 сая төгрөг батлагдсан. Төсөвт өртгөөр бус батлагдсан санхүүжилтийн дүнг баримтлан шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4³-г зөрчсөн.
- Баянцогт сумын төвийг камержуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар байгуулсан. Ажлын хэсгийн гишүүд тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

² ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх

³ Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно

- Баянчандмань сумын төвийн 4 худаг засварлах ажлын үнэлгээний хороо Засаг даргын захирамжаар томилсон байна. Үнэлгээний хороо 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдөр тендерийг нээж захиалагчид 2020 оны 06 дугаар сарын 08-ны өдөр дүгнэлт хүргүүлэхдээ тендерийг 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдөр нээсэн гэж зөрүүтэй бичсэн.
- Лүн сумын гэрэлтүүлэг засварын ажлын төсөвт өртөгт захиалагчийн албаны зардал 0.3 сая төгрөг гэж батлагдсан байхад тендерийн бичиг баримтад заавал тооцож ирүүлэх зардлын тооцоо захиалагчийн зардал 0.2 сая төгрөг гэж тусгасан байна.⁴
- Сүмбэр сум гудамжны гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажилд 17.5 сая төгрөг батлагдаж тендер зарлаж, Бүрэн цэнгэл ХХК 15.1 сая төгрөгөөр шалгарсан, гэтэл 17.5 сая төгрөгөөр гэрээ байгуулж, 16.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон.⁵
- Баянхангай сумын төлөвлөсөн 4 төсөл арга хэмжээнээс 2 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, бүрэн хэрэгжсэн 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны баримтыг аудитад ирүүлээгүй.

Зуунмод суманд 2020 онд шинээр хэрэгжсэн 10 төсөл арга хэмжээнээс 3 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, бусад 7 төсөл арга хэмжээнд Төв гэрэл ХХК-тай 144.8 сая төгрөгийн гэрээг байгуулсан байна. Зуунмод сумын ОНХС-ийн худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Номт багт Ганвон гудамжны явган хүний зам, Баянхошуу багт засмал замын хажуугаар явган хүний зам тавих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажилд үнийн санал авах урилганд үнийн санал хүлээн авах, тендерийг нээх өдрийг бичээгүй, тендерийн нээлтийн тэмдэглэлд үнэлгээний хорооны гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй, тендер шалгаруулалтад оролцож шалгарсан "Төв гэрэл" ХХК нь баримт бичигт заасан шаардлагыг хангаагүй⁶ байхад шалгаруулсан байна.

⁴ Энэ нь захиалагч болон үнэлгээний хорооноос тендерийн баримт бичгийг боловсруулж, батлахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1⁴ 19.2⁴, Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар батлагдсан "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам"-ын 5.1⁴, 5.2⁴-т заасныг тус тус зөрчсөн байна.

⁵ Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.2⁵-д заасныг зөрчсөн.

⁶ 1. ТӨӨЗ-ийн 3. Тендерийн иж бүрдэлд "... (в) Чадварын мэдээлэл санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг гэж заасан байна. Тендерт оролцогч "Төв гэрэл" ХХК-ийн хэрэгжүүлж буй ажилтай ижил төстэй ажил сүүлийн 3 жилд гүйцэтгэсэн, одоо хийж буй ажлын жагсаалтад "Төв аймгийн Баянчандмань сумын гудамжны гэрэлтүүлэг, засварын ажил, Соёл амралтын хүрээлэн гадна гэрэлтүүлэг, Зуунмод Нацагдорж багийн гэрэлтүүлэг, Баянхошуу 3-р багийн гэрэлтүүлэг, Зуунмод сумын Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, Зуунмод суманд газрын дуудлага худалдаагаар эзэмшүүлсэн газруудын гадна цахилгаан хангамж, 10/0.4 кв хүчдэлтэй, 0.4 кв чадалтай хаалттай дэд өртөө, угсралт гэрэлтүүлгийн ажил хийж байсан туршлагатай, явган хүний зам тавих ажлын туршлагын мэдээлэл байхгүй.

2. ТӨӨЗ 1.3-т "... Гэрээт ажилд ашиглах машин механизм, тоног төхөөрөмжийн жагсаалтыг маягт энэхүү дагуу ирүүлнэ "Хийн цохилт нягтруулагч 1, Автомашин 1, Зуурмаг зуурагч 1" гэж заасан боловч "Төв гэрэл" ХХК-ийн машин механизм, тоног төхөөрөмжийн жагсаалтад дээрх тоног төхөөрөмж тусгагдаагүй.

3. ТӨӨЗ 14.1 (ж)-ын 1. Доорх захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, магадалшгүй ажлын зардал, норм нормативын сан зэргийг тендерт оролцогч өөрийн төсөвт оруулж тусгана гэж заасан боловч уг зардлуудыг тооцож, төсөвт тусгаагүй.

4 ТӨӨЗ-ийн 14.1 (ж)-ын 10. "Тендерийн баримт бичигт заагдсан гэрээний Ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ гэж заасан боловч гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэлд нь огноо, дугаар байхгүй.

5 ТӨӨЗ 1.3 Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай ажиллах хүч: ..."Барилгын ерөнхий инженер тухайн байгууллагын үндсэн ажилчин байх бөгөөд ажилладаг талаар нотлох нийгмийн даатгалын

- Баруун Зуунмод багт хүүхдийн тоглоомын талбай хийх ажлын тендер шалгаруулах үнэлгээний хороо 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдөр хуралдаж 2020 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 12 цаг 00 минут хүртэл оролцогчдын материалыг хүлээн авч, 12 цаг 30 минутад нээхээр шийдвэрлэсэн боловч тендерийн нээлтийг 2020 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 11 цаг 40 минутад буюу тендерийг нээх хугацаанаас өмнө нээж, тэмдэглэл үйлдсэн байна. Үнэлгээний хорооноос 2020 оны 07 дугаар сарын 28-ны өдөр захиалагч байгууллагад гэрээ байгуулах дүгнэлтийг хүргүүлсэн боловч захиалагч байгууллага болох Зуунмод сумын ЗДТГ нь Төв гэрэл ХХК-тай 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр гэрээ байгуулсан байна.⁷
- Номт, Зүүндэлгэр багуудын нутаг дэвсгэрт гадна гэрэлтүүлэг шинээр хийх ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороо 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр хуралдаж 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 14 цаг 00 минут хүртэл оролцогчдын материалыг хүлээн авч, 14 цаг 30 минутад нээхээр шийдвэрлэсэн боловч тендерийн нээлтийг мөн өдрийн 14 цаг 00 минутад буюу тендерийг нээх хугацаанаас өмнө нээж, тэмдэглэл үйлдсэн байна. Мөн түүнчлэн тендерийн баримт бичигт тусгагдсан шалгуур шаардлагыг хангаагүй "Төв гэрэл" ХХК-ийг гүйцэтгэгчээр шалгаруулсан⁸ байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/629 тоот захирамжаар аймгийн 2020 онд хэрэгжүүлэх бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг баталсан байна. Үүгээр аймгийн ОНХС-аар хийгдэх 21 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнээс 17 ажлыг нээлттэй төсөл сонгон шалгаруулалтаар, 2 ажлыг харьцуулалтын аргаар 2 ажлыг шууд гэрээгээр худалдан авалтаар хийхээр төлөвлөгдсөн. 2020 оны 07 дугаар сарын 20-ны А/393 дугаар захирамжаар 3 ажил нэмэгдэж, 1 ажлыг харьцуулалтын аргаар, 2 ажлыг шууд гэрээгээр хийхээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт оруулжээ.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг авч үзвэл 10 ажлыг нээлттэй төсөл сонгон шалгаруулалтаар, 5 ажлыг харьцуулалтын аргаар, бусад 9 төсөл, арга хэмжээг шууд гэрээгээр худалдан авалт хийсэн байна.

Мөн Аймгийн Засаг даргын дээрх захирамжийн хавсралтаар зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл, ажлын даалгаврыг бэлэн болгож, гүйцэтгэлд хяналт тавих үүрэг бүхий захиалагч байгууллагуудыг баталсан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заагдсан хугацаанд үнэлгээний хороо байгуулж, тендер шалгаруулж, гэрээ байгуулсан байдлыг авч үзэхэд 2020 онд 7 ажлын хувьд үнэлгээний хороог байгуулахдаа худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанаас 8-115 хоногоор хэтэрч байгуулсан, тендер зарлах хугацааг 8-137 хоногоор хэтрүүлэн зарласан, бусад ажлын хувьд төлөвлөгөөнд заасан хугацааг мөрдсөн байна.

дэвтрийн хуулбарыг хамт ирүүлнэ." гэж заасан боловч "Төв гэрэл" ХХК-ийн удирдах болон инженер техникийн ажилдтаны товч тодорхойлолтод барилгын ерөнхий инженер гэх албан тушаал, барилгын инженер мэргэжилтэй ажилтан байхгүй байна.

⁷ Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.2-г⁷ зөрчиж, тендерийн хүчинтэй байх хугацаа дууссаны дараа гэрээг байгуулсан байна.

⁸ ТООЗ 1.3-т "...Гэрээт ажилд ашиглах машин механизм, тоног төхөөрөмжийн жагсаалтыг маягт энэхүү дагуу ирүүлнэ "Кран /5 тонноос дээш даацтай/, ачааны автомашин 5 тонноос дээш даацтай, таслагч суурь машин 1, гүний доргиулагч 1, арматур матагч суурь машин 32 мм 1, нивлер 1", "... ТООЗ 5.3 (в)-1, ТООЗ 5.3 (в)-2, ТООЗ 5.3 (в)-3, ТООЗ 5.3 (в)-4-д заасан шаардлага нөхцөлийн аль нэгийг хангаагүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно" гэж заасан боловч тус компанийн машин механизм, тоног төхөөрөмжийн жагсаалтад авто кран 3 тонн, бага оврын ачааны машин 1 гэж тусгасан

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо ХАА-г зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХууль, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийг баримтлан ажилласан байна. 2020 онд бүх тендерийг цахимаар зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороод ТББ-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу шаардлага хангасан аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулсан байдлыг шалгахад дараах зөрчил илэрсэн. Үүнд:

Гэр хорооллыг дулаан, цэвэр усан хангамжийн шугам сүлжээнд холбох /Төв, Зуунмод сум 2, 4, 5, 6-р баг/ ажилд Мөнхчандмань илч ХХК шалгарсан, ТББ-н ТӨӨЗ 5.2 (д) 1. Сүүлийн 2 жилийн /2018, 2019 он/ хугацаанд доод тал нь нэг удаа тендерт санал болгож буй барилга угсралтын ажилтай ижил, төстэй ажлыг гүйцэтгэх гэрээний ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байх ба энэхүү гэрээ (ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн тэр гэрээ)-ний үнэ нь энэ тендерт санал болгож буй ажлын төсөвт өртгийн 40 хувиас багагүй байж, нотлох баримтыг ирүүлнэ гэж заажээ. Компаниас ирүүлсэн баримтад /файл 4-д/ 40 хувь буюу 244.0 сая төгрөгөөс дээш дүнтэй ажил байхгүй байна.

Хүчдэлийн уналттай айл өрхийн 10/ 0.4 кв -ын ЦДАШ барих, 0.4 кв-ын эрчим хүчний шугам, сүлжээний өргөтгөл шинэтгэл хийх ажилд Төв гэрэл ХХК шалгарсан. Захиалагч байгууллагад хүргүүлсэн үнэлгээний хорооны дүгнэлтэд "Тусгал төв" ХХК буруу бичсэн байна.

Аймгийн хэмжээнд 26 суманд бэлчээрийн худаг шинээр гаргах ажил /Багц 1/, аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт хяналтын монитор худалдан авах ажилд оролцогчдоос гомдол гарч, Сангийн яаманд хянагдаж гаргасан гомдол үндэслэлтэй гэж үзэн үнэлгээг дахин хийх, тендер дахин зарлахаар шийдвэрлэсэн байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар Нийтийн номын сангийн барилгын их засварын ажлын захиалагчаар "БЗОСК" ОНӨААТҮГ томилогдсон боловч ХАА зохион байгуулагдсаны дараа зураг төсвийн ажилд ГХБХБГ хяналт тавьж ажилласан гэсэн шалтгаанаар захиалагчаар ГХБХБГ томилогдсон. ГХБХБГ нь захиалагчаар томилогдоогүй байхдаа ХАА-ны явцад захиалагчийн үүргийг гүйцэтгэсэн байна.

Дээрх илэрсэн зөрчлүүдээс үзэхэд худалдан авах ажиллагааг хуулийн дагуу үнэн зөв хэрэгжүүлж чадахгүй байна.

А.3 Сумдын 2020 оны ОНХС-ийн хэрэгжилтийг авч үзвэл нийт батлагдсан ажлын 54.3 хувь нь огт хэрэгжээгүй байна.

Аймгийн 27 сумын дүнгээр ОНХС-аар нийт 3,497.6 сая төгрөгийн 207 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ батлагдсан байна. Үүнээс 1,567.7 сая төгрөгийн 117 ажилд гэрээ байгуулж, 1,065.6 сая төгрөгийн 82 ажил бүрэн, 399.1 сая төгрөгийн 14 ажил дутуу хэрэгжиж, 1,899.5 сая төгрөгийн 89 ажил огт хэрэгжээгүй байна.

Сумдын 2020 оны ОНХС-ийн хэрэгжилтийг авч үзвэл нийт батлагдсан ажлын 54.3 хувь нь огт хэрэгжээгүй байна. Энэ нь сумдын ОНХС-аар хэрэгжүүлэх зарим

хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнүүд нь төлөвлөлтийн алдаа болон санхүүжилт оройтсон, бүх нийтийн хөл хорио зэргээс шалтгаалсан байна.

Сумдын ОНХС-ийн төлөвлөгөөний хэрэгжилттэй холбоотой зарим нэг зөрчил илэрсэн. Үүнд:

- Архуст сум гэрээ байгуулагдсан 9.9 сая төгрөгийн хүлэмж барих, 6.7 сая төгрөгийн ЕБС-ийн биеийн тамирын талбай тохижуулах нийт 16.6 сая төгрөгийн 2 ажлыг хүлээж аваагүй, гэрээний хугацаа хэтэрсэн.
- Дэлгэрхаан сум 43.0 сая төгрөгийн эрүүл мэндийн төвийн эхийн амрах байр барих ажил, 73.1 сая төгрөгийн хуучин соёлын төвийн барилгын засварын 2 ажил гэрээнд заасан хугацаанаас 50-90 хоногоор хэтэрсэн, актаар хүлээж аваагүй.
- Өндөрширээт сумын төвийн хойд, урд худгийн тохижилт, цэвэршүүлэх төхөөрөмж тавих, цахим системд нэвтрүүлэх 25.8 сая төгрөгийн гэрээт ажлын санхүүжилтийг олгохдоо захиалагчийн зардлыг суутган тооцоогүй байна. 2.6 сая төгрөгийн гэрэлтүүлэг засвар үйлчилгээний ажлын гүйцэтгэл дутуу, комиссын актаар хүлээж аваагүй байна.
- Эрдэнэ сум 60.0 сая төгрөгийн Замтын даваа засах ажлын гэрээний хугацаа хэтэрсэн, хугацааг сунгасан байна.
- Баянжаргалан сум нийтийн биеийн тамирын талбайн тохижилтын 2.2 сая төгрөг, эмнэлгийн бохирын цооногийн 1.3 сая төгрөгийн, худаг, худгийн цооног гаргах ажлын 1.3 сая төгрөгийн, бүгд 4.8 сая төгрөгийн захиалагчийн албаны зардлыг суутган тооцоогүй байна. Нийтийн биеийн тамирын тохижилтын 41.6 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл дутуу буюу суурь цутгалтын ажил дутуу байхад комиссын актаар хүлээн авсан.
- Угтаалцайдам сум ахмадын өргөө барихад 9.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж санхүүжигдэн, сумын ахмадын хорооны дарга, гишүүд 4 хүн хүлээн авсан бөгөөд 46.1 сая төгрөгийн барилга хүлээн авсан тухай акт бичигдсэн байна. Сум орон нутгаас томилогдсон ажлын хэсэг хүлээж аваагүй, 45.0 сая төгрөгөөр данс бүртгэлд тусгагдсан, хэдэн төгрөгийн төсөвт өртөгтэй барилга болох нь тодорхойгүй барилгын ажлыг гэрээгээр гүйцэтгүүлжээ. Мөн 8.0 сая төгрөгийн мал угаалгын ванныг актаар хүлээж аваагүй байна.
- Баянчандмань сумын төвд шинээр гэрэлтүүлэг тавих ажилд гүйцэтгэгч "Эс эм жи ти" ХХК-тай гэрээ байгуулж, ажлаа дуусган хүлээн авсан ч санхүүжилтийг олгоогүй. Замт багийн сайжруулсан зам засах ажлын урьдчилгаа олгосон ажил дуусаагүй.
- Борнуур сумын төвийн хаягжуулалтын ажилд Авто замын гэрлэн Дохио ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгэсэн ч гэрээ дүгнэсэн актыг Сүлжээт зам ХХК-тай үйлдсэн байна.
- Лүн сумын төвийн үерийн суваг шуудуу хийх ажилд 2019 онд 29.8 сая төгрөгийн гэрээ байгуулж, 8.9 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, олгогдсон хэдий ч хэрэгжиж дуусаагүй.
- Сэргэлэн сумын ЕБС-ийн спорт заалны их засварын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комисс 2020 оны 10 дугаар сарын 17-ны өдөр дүгнэлт үйлдсэн. Уг дүгнэлтэд захиалагч, гүйцэтгэгчийн мэдээллийг тусгаж, талууд гарын үсэг зуран баталгаажуулсан ч ямар барилга байгууламжийг, хэдий хугацаанд хэрхэн, ямар чанартай гүйцэтгэсэн тухай тэмдэглээгүй, уг дүгнэлтийг хэлбэрийн төдий хийсэн.
- Зуунмод сумын ЗДТГ-ын ариун цэврийн өрөөний сантехник, цахилгааны засварын ажилд "Төв гэрэл" ХХК-тай 5.8 сая төгрөгийн гэрээ байгуулсан,

засварын ажилд "Тусгал төв" ХХК-тай 7.2 сая төгрөгийн гэрээ байгуулж, санхүүжилтийг бүрэн олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5⁹, 41 дүгээр зүйлийн 41.2.2¹⁰, Сангийн Сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.1, 4.2, 4.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Зуунмод сумын Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/27 дугаар захирамжаар ЗДТГ-ын бие засах газрын засварыг хүлээн авах ажлын хэсгийг байгуулсан байхад уг ажлын хэсэг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын актыг 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр үйлдсэн байна.

- Баяндэлгэр суманд ОНХС-аас 12 төсөл арга хэмжээ батлагдсанаас 5 ажил нь өмнөх оноос дамжиж ирсэн ажил байна. Тухайлбал мал угаалгын банн хийх ажил сүүлийн 4 жил дараалан батлагдсан ч хийгдээгүй байсаар байна.
- Заамар сумын Ногооны зоорь барих ажил гэрээнд заасан хугацаанаас 160 хоног хэтэрч хүлээлгэн өгсөн байна.

Сумдын ОНХС-н хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлүүдэд санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага бичигдэж, зөвлөмжүүд өгөгдсөн.

Аймгийн ИТХ-н 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 02 тоот тогтоолын хавсралаар 2020 онд аймгийн ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалтыг 21 арга хэмжээнд 4,510.0 сая төгрөг зарцуулахаар баталсан. Аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 03 тоот тогтоолоор аймгийн төсөвт тодотгол хийж, ОНХС-ийн хөрөнгөөр 32 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг 4,122.2 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр жагсаалт батлагдсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнүүдээс доорх ажлууд бүрэн хэрэгжээгүй байна.

- Зуунмод сум 2, 4, 5, 6-р багийн гэр хорооллыг дулаан, цэвэр усан хангамжийн шугам сүлжээнд холбох ажилд Мөнхчандмань илч ХХК шалгарч ажлын гүйцэтгэл 71.7 хувьтай байна. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол гарч дахин тендер зарлаж гүйцэтгэгчтэй 2020 оны 10 дугаар сарын 12-нд гэрээ байгуулсан, 11 дүгээр сараас бүх нийтийн хөл хорио тогтоосонтой холбоотойгоор 4 дүгээр багийн ажил дутуу, 2 дугаар багийн ажил хийгдээгүй байна.
- Аймгийн нэгдсэн эмнэлэгт угаалгын байрны барилга барих ажилд 2 удаа тендер зарлаж Өгөөмөр бурхант ХХК гүйцэтгэгчээр шалгарч ажил эхлүүлэн 34.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд энэ ажлын тендерийг 2020 оны 01 дүгээр сарын 25-нд зарлахаар тусгасан боловч 06 дугаар сарын 12-нд зарласан, эхний тендерээр оролцогч шалгараагүй, дахин тендер зарласан зэргээс болж хугацаа алдаж энэ ажил бүрэн хэрэгжээгүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 46 дугаар зүйлийн 46.1.8¹¹-д заасныг баримтлаагүйгээс болсон байна.
- Аймгийн хэмжээнд 26 суманд бэлчээрийн худаг шинээр гаргах ажлыг 3 багц болгон тендер зарлаж, гүйцэтгүүлсэн. 1 дүгээр багц буюу Голден хилл ХХК-ний гүйцэтгэсэн 9 сумаас Лүн суманд цооног өрөмдөөд ус гараагүй учраас

⁹ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

¹⁰ Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах

¹¹ Барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх

актаар хүлээж аваагүй. 11.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 5.8 сая төгрөг буюу гэрээний үнийн дүнгийн 50 хувийг олгосон байна.

- Аймгийн Нийтийн номын сангийн барилгын их засварын ажлын орон нутгийн оролцоонд аймгийн ИТХ-аас 225.8 сая төгрөгийг баталсан. Тус засварын ажил нь БНСУ-ын хөрөнгө оруулалтаар хийгдэж гүйцэтгэгчээр "Нумт өргөө" ХХК шалгарч 1,145.8 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Аймгийн ОНХС-аас зураг төслийн мөнгө, гүйцэтгэгчид олгох санхүүжилтийг 8 дугаар сар гэхэд бүрэн олгосон. Дундын санхүүжилт хугацаандаа хийгдээгүй гэсэн шалтгаанаар гэрээний хугацааг сунгасан хэдий ч нэмэлт ажлын гэрээний дүнг оруулан нийт 1,188.3 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн боловч ашиглалтад ороогүй байна.
- Баянцогт, Өндөрширээт, Дэлгэрхаан, Цээл сумдын ЕБС, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийг бусад хөрөнгө оруулагч нартай хамтран байгуулахад орон нутгийн оролцоонд 140.0 сая төгрөг батлагдсан. Уг ажилд захиалагч байгууллага томилогдоогүй. Үүнээс Өндөрширээт сумын 100 хүүхдийн дотуур байрны цэвэрлэх байгууламжийг Атмор ХХК-иар хийлгэж аймгийн ОНХС-с орон нутгийн оролцооны 35.0 сая төгрөг олгосон. Баянцогт сумын ЕБС-ын ариун цэврийн байгууламжийг Тэнгэрийн долоон од ХХК-иар гүйцэтгүүлж 35.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Дэлгэрхаан, Цээл сумдад уг ажил хэрэгжээгүй байна.
- Зуунмод сумын шинэ Авто вокзалын гадна тохижилтын талбайн ус зайлуулах далангийн /5-р багийн үерийн далан/ ажлыг олон нийтийн оролцоотой хийх гэсэн ажилд 25.0 сая төгрөг батлагдаж Төв АЗЗА ХК гүйцэтгэгчээр шалгарсан. Үерийн ус зайлуулах байгууламжийн ажил 2020 онд хийж гүйцэтгэхээр гэрээтэй боловч 41.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь зураг төслийг гүйцэтгэсэн компани зургийн өндөржилтийг зөрүүтэй хийснээс улаан шугам тавихад хугацаа алдсан. Улмаар цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан гадна температур хасах хэмд хүрч хүйтэрсэн тул бетон цутгалтын ажил хийгдэх боломжгүй болсонтой холбоотой байна.
- Аймгийн нэгдсэн эмнэлгийн төвлөрсөн ариутгалын тасгийн цахилгааны засвар шинэчлэлийн ажилд 30.0 сая төгрөг батлагдаж Төв гэрэл ХХК гүйцэтгэгчээр шалгарсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр тендерийг 2020 оны 07 дугаар сарын 25-нд зарлах байсан боловч 11 дүгээр сарын 03-нд зарлаж, 11 дүгээр сарын 18-нд гэрээ байгуулсан. Тендер зарлахад хугацаа алдаж улмаар бүх нийтийн хөл хорио тавигдсантай холбоотой уг ажил 76 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Зуунмод суманд замын орц, гарц дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дуут дохио байршуулах ажилд 3.0 сая төгрөг батлагдаж, Өнөр дэвжих ирээдүй ХХК-тай гэрээ байгуулж санхүүжилтийг бүрэн олгосон боловч хэрэгжээгүй.

Гэрээнд заасан хугацаанд ашиглалтад ороогүй дутуу буюу бүрэн хэрэгжээгүй ажлуудад зөрчлийг арилгах, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага бичигдсэн.

Дээрх ажлуудаас гадна Угтаалцайдам сумын ЭМТ-ийг цэвэрлэх байгууламжтай болгоход дэмжлэг үзүүлэх орон нутгийн оролцоонд 18.5 сая төгрөг батлагдсан хэрэгжээгүй, өмнөх оноос дамжсан инженерийн хийцтэй худаг гаргах ажилд /Багц-3/ 4.3 сая төгрөг үлдэгдэл санхүүжилт олгохоор батлагдсан ч олгогдоогүй байна.

Тодотгосон төлөвлөгөөгөөр батлагдсан жагсаалтаар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийт 32 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ хэрэгжихээс 8 ажилд гэрээ

байгуулсан боловч бүрэн хэрэгжээгүй, 2 ажил огт хэрэгжээгүй, бусад 22 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.

Үүнээс гадна аймгийн ОНХС-ийн нийт дүнд суурь зарлагаар 464.2 сая төгрөг батлагдсанаас мал эмнэлэг үйлчилгээний зардалд 232.6 сая төгрөг, ус түгээх байрны санхүүжилт 102.0 сая төгрөг, гэрэлтүүлгийн зардалд 74.5 сая төгрөг зарцуулсан.

Аймгийн ОНХС-аас аймгийн баяр наадмын зардалд 50.0 сая төгрөг зарцуулахаар батлагдсанаас 45.9 сая төгрөг зарцуулсан. Үүнээс аймгийн Үндэсний бөхийн холбоонд бөхчүүдийн гал эргэх зардал гэж 1.5 сая төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2-т заасан аймгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй байна.

А.4 Хөрөнгө оруулалтаар шинээр бий болсон хөрөнгийг комиссын актаар хүлээж авч байгаа боловч ашиглагч эзэмшигч байгууллагын данс бүртгэлд тусгуулах ажил хийгдээгүй байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 2020 онд хийгдэж, ажил хүлээж авах комиссын актаар хүлээн авсан боловч ашиглагч, эзэмшигч байгууллагыг тодорхой болгож, данс бүртгэлд тусгуулах шаардлагатай дараах барилга, их засварын ажлууд байна.

- Бүжинхэн цэцэрлэгийн А,Б байр дээврийн их засварын ажил
- Газрын дуудлага худалдаагаар зарагдсан газруудад дэд бүтэц байгуулах ажлын цахилгаан шугам сүлжээний ажил
- Зуунмод сумын 2, 4, 5, 6-р багийн гэр хорооллыг дулаан, цэвэр усан хангамжийн шугам сүлжээнд холбох ажил
- Алтанбулаг сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих ажил
- Зуунмод сумын Соёлын төвийн их засварын ажил
- Аймгийн Нийтийн номын сангийн барилгын их засварын ажил
- Мөнгөнморьт, Заамар, Эрдэнэ, Дэлгэрхаан сумдын орон нутгийн гүүр, хоолойн засвар
- Баянцогт, Өндөрширээт сумдын ЕБС, дотуур байрны ариун цэврийн байгууламж /бусад хөрөнгө оруулагч нартай хамтран хэрэгжүүлэх орон нутгийн оролцоо/

Дээрх ажлуудыг ашиглагч болон эзэмшигч байгууллагуудын данс бүртгэлд тусгуулах албан шаардлага бичигдсэн.

Сумдын хувьд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнүүдийг нягтлан бодох бүртгэлийн данс бүртгэлд тусгасан байна.

Аймаг, сумдын ОНХС-ын хөрөнгөөр сумдад 1,065.6 сая төгрөгийн 82, аймагт 3,939.9 сая төгрөгийн 30 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ хэрэгжсэн байна.

БҮЛЭГ Б. Шилжих үлдэгдлийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт.

Б.1 Хөрөнгө оруулалтын чанартай 44 арга хэмжээнээс 2020 онд шинээр хэрэгжих 33 арга хэмжээ нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны үндсэн чиглэлд тусгагдсан, 2 арга хэмжээ тусгаагдаагүй байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 15 дугаар хуралдааны 02 дугаар “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” тогтоолын 5 дугаар хавсралтаар аймгийн төсвийн хөрөнгийн /шилжих үлдэгдэл/ эх үүсвэрээр барилга байгууламж шинээр барих болон их засварын ажлын 13 арга хэмжээнд 2,559.3 сая төгрөг, Зураг төсөв боловсруулах арга хэмжээнд 126.4 сая төгрөг, машин тоног төхөөрөмж авах 6 арга хэмжээнд 701.0 сая төгрөг, бусад төсөл арга хэмжээнд 1,480.0 сая төгрөг, нийт 4,866.7 сая төгрөг батлагдсан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 03 тоот тогтоолоор аймгийн төсөвт тодотгол хийж өмнөх тогтоолын хавсалтаар батлагдсан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд зарим өөрчлөлт оруулсан. Анх батлагдсан хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулахдаа хэрэгжээгүй, хэрэгжээд хэмнэлт гарсан болон шинээр бий болсон эх үүсвэрийг шинэ төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна. Тухайлбал:

- Одонт хөтлийн цахилгааны ажилд 15.0 сая төгрөг төлөвлөсөн байсныг 16.8 сая төгрөг,

- Одонт хөтлийн нэмэлт ажилд 11.3 сая төгрөг төлөвлөсөн байсныг 9.5 сая төгрөг,

- ЗДТГ-ын барилга шинээр барих /Бүрэн сум/-д 500.0 сая төгрөг төлөвлөсөн байсныг 455.5 сая төгрөг,

- Зуунмод суманд дулааны станцын 2-р хэлхээний гадна шугам, сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажилд 527.5 сая төгрөг төлөвлөсөн байсныг 496.6 сая төгрөг,

- Зуунмод сумын Ланс багийн чиглэлийн 2.5 км автозамын барилгын ажил эхлүүлэхэд 353.7 сая төгрөг төлөвлөсөн байсныг 353.0 сая төгрөг,

- Зуунмод сумын нийтийн эзэмшлийн орон сууцнуудын барилгын дээврийн их засвар /18, 42, 44, 1-р байр/-т 200.0 сая төгрөг төлөвлөсөн байсныг 197.9 сая төгрөг,

- Зуунмод суманд Хүмүүн бага сургуулийн гадна талбайд авто зогсоол байгуулж, тохижилтын ажилд 60.0 сая төгрөг төлөвлөсөн байсныг 55.1 сая төгрөг,

- Мон төслийн зээлийн эргэн төлөлтөд 160.0 сая төгрөг төлөвлөсөн байсныг 80.0 сая төгрөг,

- Төрийн үйлчилгээний хур систем нэвтрүүлэх ажилд 250.0 сая төгрөг төлөвлөсөн байсныг 101.7 сая төгрөг,

- Аймаг хөгжүүлэх сангийн эх үүсвэрт 600.0 сая төгрөг төлөвлөсөн байсныг 500.0 сая төгрөг,

- ЗДТГ-ын суудлын автомашин шинэчлэл /Сэргэлэн, Баянхангай, Батсүмбэр, Баянцогт, Сүмбэр, Жаргалант сум, аймгийн ЗДТГ/-д 400.0 сая төгрөг төлөвлөсөн байсныг Аймгийн ЗДТГ-ын суудлын автомашин шинэчлэл болгон 80.0 сая төгрөг,

- Баянчандмань сумын ЭМТ-ийг тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангахад 31.5 сая төгрөг төлөвлөсөн байсныг 31.1 сая төгрөг,

- Аймгийн хэмжээний төсөвт байгууллага, газар, хэлтэс, агентлагуудын автомашин шинэчлэх зардал /Цагдаа, Өмчийн газар, ШШАлба, Прокурорын газар/-д 150.0 сая төгрөг төлөвлөсөн байсныг 151.0 сая төгрөг,

- Батсүмбэр сумын ЭМТ-ийн лабораторийн тоног төхөөрөмж шинэчлэх, худалдан авахад 44.5 сая төгрөг төлөвлөсөн байсныг 37.0 сая төгрөг,

- Сумдыг багийн явуулын төвийн тоног төхөөрөмжөөр хангах /Аргалант, Архуст, Баяндэлгэр, Заамар, Мөнгөнморьт, Цээл/-д 40.0 сая төгрөг төлөвлөсөн байсныг 38.6 сая төгрөг,

- Гадаадын иргэн харьяатын газарт тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авахад 35.0 сая төгрөг төлөвлөсөн байсныг 34.3 сая төгрөг болгон өөрчилж, шинээр гадна тохижилт, урсгал засвар, орон нутгийн оролцоо, дэмжлэг зэрэг 18 төсөл арга

хэмжээнд 871.7 сая төгрөг, нийт 44 төсөл арга хэмжээнд 4,998.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталсан байна.

Аймгийн эдийн засгийн бүсчлэлийн төсөл боловсруулах ажлыг төлөвлөгөөнд тусгахдаа төсөвт өртгийг 20.0 сая төгрөг, үүнээс 2020 онд санхүүжих дүн 40.0 сая төгрөг гэж төсөвт өртгөөс давсан үнээр санхүүжилтийг олгохоор баталсан.

Аймгийн ИТХ-н 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаар “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” тогтоолоор Одонт хөтлийн цахилгааны ажилд 15.0 сая төгрөг, Одонт хөтлийн нэмэлт ажилд 11.3 сая төгрөг төсөвлөж, гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан 2020 оны 04 дүгээр сард санхүүжилтийг тус тус олгосон байхад 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 3 дугаар тогтоолоор Одонт хөтлийн цахилгааны ажилд 16.8 сая төгрөг, Одонт хөтлийн нэмэлт ажилд 9.5 сая төгрөг болгон өөрчлөн баталсан байна.

Хөрөнгө оруулалтын чанартай 44 арга хэмжээнээс 2020 онд шинээр хэрэгжих 33 арга хэмжээ нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны үндсэн чиглэлд тусгагдсан Аймгийн эдийн засгийн бүсчлэлийн төсөл боловсруулах, Атарчдын талбай орчмын тохижилтын ажил гэх 2 арга хэмжээ тусгагдаагүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна гэснийг зөрчсөн байна.

Б.2 Худалдан авах ажиллагаатай холбоотой өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүд давтан гарсаар байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/629 дүгээр захирамжаар шилжих үлдэгдлээр хийгдэх 21 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнээс 11 ажлыг нээлттэй төсөл сонгон шалгаруулалтаар, 8 ажлыг харьцуулалтын аргаар 2 ажлыг шууд худалдан авалтаар хийхээр баталсан. Шилжих үлдэгдлээр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд өөрчлөлт орсонтой холбоотойгоор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан. Тус худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд аймгийн эдийн засгийн бүсчлэлийн төсөл боловсруулах, аймгийн ЗДТГ-ын дулааны шугам сүлжээний урсгал засварын ажлууд тусгагдаагүй байна. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг авч үзвэл 12 ажлыг нээлттэй төсөл сонгон шалгаруулалтаар, 11 ажлыг харьцуулалтын аргаар, 2 ажлыг шууд худалдан авалт хийсэн байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заагдсан хугацаанд үнэлгээний хороо байгуулж, тендер шалгаруулж, гэрээ байгуулсан байдлыг авч үзэхэд 2020 онд үнэлгээний хороог байгуулахдаа худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанаас 4-84 хоногийн өмнө болон 8-174 хоногоор хэтрүүлэн байгуулсан байна.

2020 онд Аймгийн эдийн засгийн бүсчлэлийн төсөл боловсруулах ажлаас бусад тендерийг цахимаар зохион байгуулсан байна. Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Үнэлгээний хороо гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТББ-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу шаардлага хангасан аж ахуйн нэгжийг шалгаруулсан байдлыг шалгахад дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Аймгийн Цагдаагийн газрын эрүүлжүүлэх саатуулах байрны өргөтгөл, их засварын ажлын тендерт шалгарсан БУТОЗМ ХХК нь ТШӨХ-ийн ТӨӨЗ 2.3-т заасан өгөгдөл, шаардлагыг хангаагүй ирүүлэхээр заасан материалын бүрдэл дутуу

байхад ажил хийх хугацаагүй боллоо гэх шалтгаанаар үнэлгээний хорооны гишүүдийн 75 хувийн саналаар тендерт шалгаруулсан¹²,

Уг зөрчил нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараах шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ”, 27.1.1-д “энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхын шаардлага”, 27.1.2-т “техникийн тодорхойлолт”, 27.1.3-д “тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага” гэснийг зөрчсөн байна.

Өмнөх онд хийгдсэн “Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар аймгийн Орон нутгийн өмчийн газарт “Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт буюу тухайн тендерт тавигдсан шалгуурыг хангаагүй, тендерийн баримт бичгийн бүрдэл дутуу аж ахуйн нэгжийг тендерт шалгаруулсан зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх” зөвлөмжийг өгсөн боловч зөрчлийг давтан гаргасан байна.

Мөн худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Одонт хөтлийн цахилгааны ажлыг 15.0 сая төгрөгөөр, Одонт хөтлийн нэмэлт ажлыг 11.3 сая төгрөгөөр 2019 онд шууд гэрээ байгуулан, хүлээн авсан ба тухайн онд төсөвт нь тусгагдаагүй байсныг 2020 оны 04 дүгээр сард аймгийн Засаг дарга захирамж гарган санхүүжилтийг олгож, 2020 оны 09 дүгээр сард тодотголоор санхүүжих дүнг өөрчлөн баталсан байна.¹³
- Дулааны станцын 2-р хэлхээний гадна шугам, сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил /Аймгийн төв, Зуунмод сум/ нь нийт 11,632.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил бөгөөд зураг, төсвийг 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр ДНТ ХХК 149.7 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулж, гүйцэтгэсэн байна. ХАА-г зохион байгуулахдаа зураг төсвийн үнийг оруулж тооцолгүй тендерийг зарласан байна.
- Төрийн үйлчилгээний Хур систем нэвтрүүлэх /ЗДТГ/ ажилд 250.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж ХАА-г зохион байгуулахдаа 4 багц болгосон байна. 4 дэх багц нь 178.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зохион байгуулагдаж, 33.3 сая төгрөгийн үнийн санал ирсэн. Тус төсөл, арга хэмжээний санхүүжилт ямар нэг тооцоо судалгаагүй батлагджээ. Нийт 250.0

¹² ТББ-гт ТӨӨЗ 2.3 11-т шаардлагатай инженер техникийн ажиллагсдын жагсаалтад ерөнхий инженер, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан гэх 2 албан тушаалтан шаардсан, мөн 12-т тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудыг дараах хүснэгтэд зааснаар ирүүлнэ. Тендерт оролцогч уг ажлыг гүйцэтгэхэд шаардагдах нийт багаж, техник, тоног төхөөрөмжийг нэг бүрчлэн жагсааж ирүүлсэн байна. Үүнд: ковш-1, авто ачааны машин 2, хийн цохилтот нягтруулагч 1, гадаргуугын доргиур 1, цахилгаан гагнуурын агрегат 1, цахилгаан үүсгүүр 1, автобетон зуурагч 1, гагнуурын аппарат 1, бусад тоног төхөөрөмж тоогоор. Тендерт оролцогчийн ирүүлсэн тендер нь ТШӨХ-ийн ТӨӨЗ 2.3-т заасан өгөгдөл, шаардлагыг хангаагүй ирүүлэхээр заасан материалын бүрдэл дутуу бол уг тендерээс татгалзана гэж заасан.

¹³ Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-д жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх; 6.4.8-д төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэснийг зөрчсөн байна. Мөн одонт хөтлийн цахилгааны ажилд шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дэх заалтыг зөрчсөн байна.

сая төгрөгийн санхүүжилттэй 4 багцад 101.7 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан байна.

- Зуунмод сумын нийтийн эзэмшлийн орон сууцуудын барилгын дээврийн их засвар /18, 42, 44, 1-р байр/-ын ажил нь 249.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд 200.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, батлагдсан санхүүжилтээр ХАА зохион байгуулагдсан.
- Одонт хөтлийн орчны зам, талбайн тохижилтын ажилд тендерийг 2020.03.23-ны өдөр нээсэн тендерийн хүчинтэй хугацаа 30 хоног буюу 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн дотор гэрээ байгуулах ёстой байтал гэрээг 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр буюу тендерийн хүчинтэй байх хугацаа дууссаны дараа гэрээ байгуулсан байна.¹⁴
- Аймгийн Цагдаагийн газрын эрүүлжүүлэх, саатуулах байрны өргөтгөл, их засварын ажилд үнэлгээний хорооны дарга нь үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэгт гарын үсэг зурж, баталгаажуулаагүй байна.
- Аймгийн ЗДТГ-ын дулааны шугам сүлжээний урсгал засварын ажлын үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, худалдан авах ажиллагааны баримт дутуу, архивын нэгж үүсгэн хадгалаагүй байна.
- Нэгдсэн эмнэлгийн орчмын авто зам, талбайн тохижилтын ажилд “БЗОСК” ОНӨААТҮГ-аас 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 472 тоот албан бичгээр “Төв АЗЗА” ХК-д "...нэгдсэн эмнэлэг орчмын авто зам талбайн тохижилтын ажлыг Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын шийдвэрээр танай байгууллагаар хийлгэх болсон тул үнийн саналаа яаралтай ирүүлнэ үү гэжээ. Захиалагч “БЗОСК” ОНӨААТҮГ нь хэлэлцээр хийх урилга хүргүүлэхээсээ өмнө тухайн компанитай гэрээ хийх шийдвэрийг гаргасан байна.
- Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд “БУТОЗМ” ХХК нь тендер шалгаруулалтад оролцож, ТШӨХ-н ТӨӨЗ-ны 21.1-т заасан шаардлагыг хангаагүй шалтгаанаар хасагдсан байхад “БУТОЗМ” ХХК-тай хэлэлцээр хийн, 375.6 сая төгрөгөөр 10 байр худалдан авахаар шууд гэрээ байгуулсан байна. “Өнөд сайжрах” ХХК-тай 48.4 сая төгрөгийн 1 орон сууцыг худалдан авах гэрээ байгуулсан, хэлэлцээр хийсэн баримтгүй. Захиалагч “БЗОСК” ОНӨААТҮГ-аас баталсан түрээсийн орон сууц худалдан авах ажлын даалгаварт 35-40 м2 талбай бүхий 1 болон 2 өрөө 20 ширхэг байр худалдан авахаар заасан байна. “Өнөд сайжрах” ХХК-иас 44,02 м2 талбайтай 2 өрөө 1 орон сууц, “БУТОЗМ” ХХК-иас 31.3 м2 талбайтай 2 өрөө 9 орон сууц, 44,9 м2 талбайтай 2 өрөө 1 орон сууц худалдан авсан байна.¹⁵
- Аймгийн хэмжээний төсөвт байгууллага, газар, хэлтэс, агентлагуудын автомашин шинэчлэх зардал /Цагдаа, Өмчийн газар, ШШАлба, Прокурорын газар/-д аль байгууллага хэдэн төгрөгийн машин авах нь тодорхойгүй, шийдвэр байхгүй байна. Мөн үнэлгээний хорооноос захиалагч байгууллагуудад шууд гэрээ багуулахдаа "...тендер шалгаруулалтын анхны

¹⁴ Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасныг зөрчсөн байна.

¹⁵ ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2. Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана гэх заалтыг зөрчсөн байна.

техникийн тодорхойлолтод заасан бараа бүтээгдэхүүнийг нэр төрөл болон тоо хэмжээг өөрчлөхгүйгээр авч, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу данс бүртгэлд нэр төрөл тоо хэмжээгээр нь бүртгэж, эзэмшигч, ашиглагч нартай картжуулж, хяналт, шалгалтын байгууллагад тайлагнаж ажиллах...” гэх дүгнэлтийг хүргүүлсэн байхад захиалагч Төв аймгийн Цагдаагийн газар болон Төв аймгийн ЗДТГ нь техникийн тодорхойлолтод зааснаас өөр автомашинууд худалдан авсан байна.

- Аймгийн эдийн засгийн бүсчлэлийн төсөл боловсруулах ажилд ХАА-ны ямар журмыг баримталсан нь тодорхойгүй байна. Учир нь аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн холбогдох мэргэжилтэн “...уг төсөл арга хэмжээ ажлын чиглэл, хийх арга хэмжээний нөхцөл зэргээс шалтгаалан төсөл сонгон шалгаруулалтаар хэрэгжүүлсэн...” гэх тайлбар, ОНӨГ-ийн мэргэжилтэн “...ХАА-ны хууль, журмын дагуу зохион байгуулагдах төсөл, арга хэмжээнүүд зөвхөн “Үнэлгээний хороо” нэртэй захирамж шийдвэр гаргадаг. Дээрх төсөл арга хэмжээ нь ажлын хэсэг нэртэй байгуулагдсан...” гэх тайлбарыг тус тус ирүүлсэн. Тус худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/104 дүгээр захирамжаар томилсон. Уг захирамжинд “...боловсруулах мэргэжлийн зөвлөх үйлчилгээ сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг...” гэж томилсон. Ажлын хэсэг нь үйл ажиллагаандаа ТБОНӨХБАҮХАТ хуулийг баримталж ажилласан, шийдвэрээ гаргаж захиалагч байгууллагад “Үнэлгээний хорооны дүгнэлт”-ийг хүргүүлсэн. Мөн тус ХАА-нд шалгарсан Аж Үйлдвэрийн Паркийн Технологи Дамжуулах Төв Нүтбб нь 39,854,116 төгрөгийн үнийн санал ирүүлсэн байхад гэрээг 40,0 сая төгрөгөөр байгуулсан байна.

Б.3 Шилжих үлдэгдлээр хэрэгжих 44 төсөл арга хэмжээнээс хөрөнгө оруулалтын чанартай 32 ажилд гэрээ байгуулснаас 27 ажил хугацаандаа бүрэн хэрэгжжээ.

Баян-Өнжүүл сумын 10 ортой Эрүүл мэндийн төвийн барилга барих, Бүрэн сумын ЗДТГ-ын барилга шинээр барих, Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх зардал зэрэг 3 ажлын гэрээний хугацаа дуусаагүй, Зуунмод сумын 47, 48 дугаар байрны гадна тохижилт ажил болон Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлууд нь хугацаандаа хэрэгжээгүй, он дамжин хэрэгжихээр болсон байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээ болон гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Дулааны станцын 2-р хэлхээний гадна шугам, сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажлын зураг, төсвийг 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдөр хүлээлгэж өгөх байсан боловч 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдөр гэрээг дүгнэсэн. Зураг төсвийн төсөвт өртөгт тусгасан магадалшгүй ажлын зардал 2.9 сая төгрөг, зохиогчийн хяналтын зардал 2.9 сая төгрөг, нийт 5.7 сая төгрөгийг суутгалгүй ДНТ ХХК-д олгосон байна.

- Атарчдын талбай орчмын тохижилтын ажлын гүйцэтгэгч Бодь буян ХХК-ийн ажлын зураг, төсөв магадлалаар орж баталгаажуулаагүй, ажил гүйцэтгэж, санхүүжилт авсан байна. 2019 оны 10 дугаар сарын 10-нд Бодь буян ХХК нь Төв аймгийн тариаланчдын холбоотой Атарчдын талбай байгуулах 336.0 сая төгрөгийн гэрээг байгуулсан байна. Тус гэрээнд 110.0 сая төгрөгийг аймгаас санхүүжүүлэхээр тусгасан байна. Төв аймгийн тариаланчдын холбоонд Бодь буян ХХК 336.8 сая төгрөгийн ажлаас 2020 онд 2019 оны 10-12 сарын 313.0 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл гаргаж, тус ажлын санхүүжилтэд аймгийн орон нутгийн төсвийн данснаас

Тариаланчдын холбоог 2019 онд 50.0 сая төгрөг, 2020 онд 30.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Ажлын гүйцэтгэлд 2019 онд 101.4 сая төгрөг санхүүжигдсэнээс 50.0 сая төгрөгийг аймгаас, үлдсэн 51.4 сая төгрөгийн санхүүжилт Тариаланчдын холбооноос санхүүжигдсэн гэсэн байна. Тус Атарчдын талбайн ажлын нийт гүйцэтгэл 512.0 сая төгрөг бөгөөд бодит гүйцэтгэл 199.0 сая төгрөг болж байна. Бодь буян ХХК-ий Түлхүүр гардах нөхцөлөөр гүйцэтгэсэн ажил болон 2019 онд Төв аймгийн Тариаланчдын холбоотой гэрээгээр гүйцэтгэсэн ажлууд давхцаж байна. 50.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Тариаланчдын холбооноос аймаг, орон нутагтай байгуулсан ямар нэгэн гэрээ хэлцэл байхгүй, Тариаланчдын холбоо Бодь Буян 2-ын байгуулсан гэрээгээр, аймгийн Засаг даргын захирамжаар Төсвийн шилжих үлдэгдлээс санхүүжилт олгосон байна.

- 10 ортой Эрүүл мэндийн төвийн барилга барих /Төв, Баян-Өнжүүл сум/ ажилд зураг төсөл боловсруулах гэрээг 34.8 сая төгрөгөөр байгуулсан байхад 37.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон,

- Дулааны станцын 2-р хэлхээний гадна шугам, сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажилд 496.6 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Зураг төсөл зохиогчийн хяналт хэрэгжээгүй, санхүүжилтийг олгоогүй байхад гүйцэтгэлийг 100 хувь гэж зөрүүтэй тайлагнасан,

- Аймгийн Цагдаагийн газрын эрүүлжүүлэх саатуулах байрны өргөтгөл, их засварын ажилд зураг төсөл зохиогчийн хяналтын гэрээ байгуулаагүй, зураг төсөл зохиогчийн хяналтгүй хийгдсэн. Зураг төсөл боловсруулах гэрээний төлбөр 1.5 сая төгрөгийг 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдөр ХОХБТХ-ээс Цагдаагийн газрын нэмэлт дансанд шилжүүлэх тухай санхүүжилтийн мэдэгдлийг хүргүүлсэн байхад санхүүжилтийг олгоогүй,

- Хүмүүн бага сургуулийн гадна талбайд авто зогсоол байгуулж, тохижилт хийх /Зуунмод сум/ ажилд 55.1 сая төгрөгийн гэрээ байгуулж, бүрэн хэрэгжиж дууссан. Гэрээний үнийн дүнгийн 5 хувийг чанарын баталгааны барьцаанд 1 жилийн хугацаатай барьцаалахаар гэрээнд заасан байхад хэрэгжүүлээгүй,

- Баянчандмань сумын ЭМТөвийн барилгын их засварт нэмэлт санхүүжилтэд 69.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Гэрээний үнийн дүнгийн 5 хувийг чанарын баталгааны барьцаанд 1 жилийн хугацаатай барьцаалахаар гэрээнд заасан байхад хэрэгжүүлээгүй,

- ЗДТГазрын барилга шинээр барих /Бүрэн сум/ ажлын хяналтын төсөвт зураг төсөл зохиогчийн хяналтын дүнг 8.1 сая төгрөг гэж тусгасан байхад зураг төсөл зохиогчийн хяналтын гэрээг 8.0 сая төгрөгөөр байгуулсан байна. Иймд зураг төсөл зохиогчийн хяналтын дүнг зөрүүтэй тусгасан.

Цаашид дээрх зөрчлүүдийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн акт бичигдлээ.

Б.4 Шилжих үлдэгдлээр хэрэгжих 4,998.0 сая төгрөгийн 44 төсөл арга хэмжээ төлөвлөснөөс 136.6 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Шилжих үлдэгдлээр хэрэгжих 4,998.0 сая төгрөгийн 44 төсөл арга хэмжээнээс 136.6 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна. Үүнд:

1. Татварын хэлтсийн сургалтын танхимын их засварт орон нутгийн оролцоо
2. Авто замын их засвар хийх /Борнуур сум/
3. Хөдөө аж ахуйн биржтэй хамтарч төсөл хэрэгжүүлэх
4. Сүмбэр сумын дунд сургуулийн ариун цэврийн байгууламжийг бусад хөрөнгө оруулагчтай хамтран шинэчлэх зардал орон нутгийн оролцоо

5. Аймгийн төрийн сангийн нэгдсэн сүлжээний компьютер тоног төхөөрөмжийг шинэчлэх зардал
6. Зуунмод Унагалдай цэцэрлэгийн Б Байрны явган замын засвар

Зуунмод цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж, хашаа, гүүр байгууламжийн урсгал засварын ажилд 2.2 сая төгрөгийн санхүүжилт баталсан боловч санхүүжилтийг олгохдоо аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/508 дугаар захирамжаар БОХНСАХЗ-с санхүүжүүлсэн байна.

Он дамжин хэрэгжих 5 төсөл арга хэмжээ, хэрэгжээгүй 6 төсөл арга хэмжээ, өөр эх үүсвэрээс санхүүжсэн 1 төсөл, арга хэмжээ нийт 12 төсөл арга хэмжээнээс бусад 32 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.

Баян-Өнжүүл сумын 10 ортой Эрүүл мэндийн төвийн барилга барих, Бүрэн сумын ЗДТГазрын барилга шинээр барих, Зуунмод суманд Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх зардал зэрэг 3 ажлын гэрээний хугацаа дуусаагүй, 47, 48 дугаар байрны гадна тохижилтын ажил болон Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлууд нь он дамжин хэрэгжихээр болсон байна.

Б.5 Он дамжин хэрэгжиж буй 1,390.5 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээнээс бусад хөрөнгө оруулалтын ажлуудыг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

БҮЛЭГ В. Замын сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн

В.1 Замын сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг холбогдох хууль, журмын хүрээнд төлөвлөж баталсан байна.

Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу аймгийн төсөв баталсан ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 02 тоот тогтоолын хавсралтаар Замын сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх ажлын жагсаалтыг 10 төсөл арга хэмжээг 611.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр баталсан. Аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 03 тоот тогтоолоор аймгийн төсөвт тодотгол хийгдэж, Замын сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх ажлын жагсаалтад 11 арга хэмжээг 611.0 сая төгрөгөөр хийхээр шийдвэрлэсэн. 46, 47, 48 дугаар байр орчмын хайрган хучилттай авто замын засварын ажлыг 10.2 сая төгрөгөөр хийх ажил тодотголоор нэмэгдсэн.

Аймгийн Замын сангаар 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал байршил	Хугацаа	Төсөвт өртөг	2019.12.05-ны 02 тогтоол	2020.09.10-ны 03 тогтоол	Гүйцэтгэл
1	Зуунмод хотын хотхонуудын зам талбайн тохижилт	2020	255,000.0	255,000.0	255,000.0	249,510.2
2	Усны аж ахуйн хэсгийн авто замын засвар /Төв, Зуунмод сум 5-р баг/	2020	80,000.0	80,000.0	79,689.9	79,423.9
3	Орон нутгийн чанартай авто замуудыг тэмдэгжүүлэх зардал	2020	50,000.0	50,000.0	44,415.0	44,415.0
4	Зуунмод хотын хатуу хучилттай авто замын засварын ажил	2020	50,000.0	50,000.0	47,701.2	50,625.9
5	Зуунмод сумын авто замын өвөл зуны арчлалтын ажлын зардал	2020	45,000.0	45,000.0	44,935.6	44,776.6

6	Зуунмод сумын төвийн хатуу хучилттай авто замын өдөр тутмын арчлалтын зардал	2020	35,000.0	35,000.0	35,000.0	34,873.0
7	Байгалийн болзошгүй гамшиг үерийн улмаас эвдэрсэн Үерийн хамгаалалтын далангийн засвар /Төв, Зуунмод/	2020	40,000.0	40,000.0	38,079.0	37,818.2
8	Байгалийн болзошгүй гамшиг, цас зудны үед орон нутгийн зам, давааг арчлах, сэргээн засварлах зардал	2020	40,000.0	40,000.0	40,000.0	-
9	46, 47, 48 дугаар байр орчмын хайрган хучилттай авто замын засвар	2020	-		10,179.3	10,179.3
10	Аймгийн төв доторх хотхонуудын зам талбайн тохижилтын зураг төсөл боловсруулах ажил	2020	13,000.0	13,000.0	13,000.0	13,000.0
11	Орон нутгийн чанартай авто замын хураамж төвлөрүүлэх зардал	2020	3,000.0	3,000.0	3,000.0	3,000.0
Дүн			611,000	611,000	611,000	567,622.1

Тодотгосон төлөвлөгөөгөөр Замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалт батлахдаа гүйцэтгэгчийг шалгаруулж гэрээ байгуулсан дүнгээр тодотгол хийж гарсан зөрүүгээр нь 46, 47, 48 дугаар байр орчмын хайрган хучилттай авто замын засвар ажил нэмж баталсан.

В.2 Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих 10 ажлаас 7 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар гүйцэтгэгчийг шалгаруулж, 1 ажлыг зөвлөх үйлчилгээний тендерээр, 1 ажлыг шууд гэрээ байгуулсан, 1 ажил хэрэгжээгүй байна.

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн Зуунмод хотын хотхонуудын зам талбайн тохижилтын ажилд Хишиг буянт зам ХХК шалгарсан. Тендерийн баримт бичгийн ТООЗ 5.2.(в) ТШМ-2-1.5 хүснэгтэд заасан 5-н инженер, техникийн ажилтан, ажилчид тендерт оролцогчийн үндсэн ажилчид байна. Үүнийг нотолж №ТШМ-2-1.5 хүснэгтэд заасан инженер, техникийн ажилтан, ажилчдын нэрийн дагуу 2019 оны 1-12 дугаар саруудын нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн баримт бичгийг /НД-7, НД-8 маягт, лавлагааг/ нийгмийн даатгалын байгууллагаар баталгаажуулж ирүүлэхийн зэрэгцээ Нийгмийн даатгалын дэвтрийн 1 дүгээр хуудас болон "даатгуулагчийн ажил албан тушаалын өөрчлөлтийн тэмдэглэл"-ийн хуулбарыг нотариатаар баталгаажуулж ажилд томилсон тушаалын хамт ирүүлнэ. №ТШМ-2-1.5 хүснэгтэд заасан үндсэн шаардлага, мөн ТООЗ 5.2-ын (в)-ын 1, 2-д заасан өгөгдөл, шаардлагуудын аль нэгийг хангаагүй бол тухайн тендерээс татгалзана гэсэн байна. Гэтэл тендерт шалгарсан компанийн ирүүлсэн тендерийн материалд 2019 оны 9 дүгээр сараас эхлэн 5 хүнээр НД тайлан гаргасан түүнээс өмнө 1-8 дугаар саруудад 2-4 хүнээр НД-н тайлан гаргажээ, өөрөөр хэлбэл тендерт тавигдсан шаардлагыг хангаагүй байхад шалгаруулсан байна.

В.3 Гэрээ байгуулсан ажлууд гэрээнд заагдсан хугацаанд хийгдэж комиссын актаар хүлээлгэн өгсөн байна.

Батлагдсан 11 ажил, арга хэмжээнээс замын хураамж төвлөрүүлэх ажил, хэрэгжээгүй ажлаас бусад 9 ажилд гэрээ байгуулагдсан. Гэрээ байгуулсан ажлууд гэрээнд заагдсан хугацаанд хийгдэж комиссын актаар хүлээлгэн өгсөн байна.

В.4 Замын сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн байна.

Байгалийн болзошгүй гамшиг, цас зудын үед орон нутгийн зам, давааг арчлах, сэргээн засварлах зардалд 40.0 сая төгрөг батлагдсан, тухайн ажилд зарцуулах шаардлага гараагүй тул хэрэгжээгүй. Бусад батлагдсан ажлууд бүгд хэрэгжсэн.

Зуунмод хотын хотхонуудын зам талбайн тохижилтын /хуульчдын хотхоны урд тавигдсан автозам/ ажил болон Зуунмод хотын хатуу хучилттай авто замын засварын ажилд Хишиг буянт зам ХХК гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулан ажилласан. Зуунмод хотын хатуу хучилттай авто замын засварын ажилд 47.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан байхад 50.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Захиалагч байгууллагаас гаргасан гүйцэтгэл, түүнийг хянаад бичигдсэн санхүүжилтийн даалгаварт 46.8 сая төгрөгөөр гүйцэтгэлийг гарган санхүүжилт олгогдохоор СТСХ-т хүргүүлсэн боловч 49.8 сая төгрөг буюу 3.0 сая төгрөг илүү дүнгээр төлбөрийн даалгавар бичигдэж санхүүжилт хийгджээ. Илүү олгосон санхүүжилтээ гэрээ байгуулсан нөгөө ажил болох Зуунмод хотын хотхонуудын зам талбайн тохижилтын санхүүжилтээс суутган тооцсон байна. Энэ нь ажил хариуцсан ажилтнуудын хариуцлагагүй, хайнга байдлаас шалтгаалсан байна.

ИТХ-аар батлагдсан жагсаалтад байхгүй Өндөрширээт сумын Туул голын Хэрмэн дэнжийн гүүр, хиймэл байгууламжийн ажлын санхүүжилтэд аймгийн Засаг даргын 2020 оны №А/355 тоот захирамжаар 10.0 сая төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1¹⁶, 65 дугаар зүйлийн 65.1¹⁷-д заасныг тус тус зөрчсөн байна.

Аймгийн Замын сангаар 2020 онд хэрэгжүүлэх ажилд 611.0 сая төгрөг батлагдсанаас 577.6 сая төгрөг зарцуулагдаж 33.4 сая төгрөг хэмнэгдсэн байна.

В.5 Замын сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдсэн ажлуудыг комиссын актаар хүлээж авсан хэдий ч эзэмшигч, ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгаагүй байна.

Хуульчдын хотхоны урд хийгдсэн авто зам, 46, 47, 48 дугаар байр орчмын хайрган хучилттай авто зам болон шинээр хийгдсэн замын тэмдэг, зам засварын нийт 485.2 сая төгрөгийн ажлыг Зуунмод сумын ЗДТГ-ын данс бүртгэлд тусгуулах албан шаардлага бичигдсэн.

¹⁶ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 64.1.2.тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх;

¹⁷ Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 65.1.1.тухайн шатны төсвийн төсөл, тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;

Аймгийн Замын сангаар 2020 онд хэрэгжүүлэх 11 ажилд 611.0 сая төгрөг батлагдсанаас 10 ажилд 577.6 сая төгрөг зарцуулагдаж 33.4 сая төгрөг хэмнэгдсэн байна.

БҮЛЭГ Г. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Г.1 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний жагсаалтад орсон нэг ажилд гүйцэтгэгч байгууллагыг нэр заан баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар БОХНСАХЗ-аар 743.1 сая төгрөгийн 19 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 18 дугаар хуралдааны 3 дугаар "Аймгийн 2020 оны тодотгосон төсөв батлах тухай" тогтоолоор өөрчлөлт ороогүй.

Жагсаалтад "Лүн сум дах сум дундын ойн ангид хариуцуулан, Зуунмод суманд хийгдэх "Ногоон паспорт-Ногоон төгөл" ойн зурвасыг өргөжүүлж, 1100 ширхэг навчит мод, гоёлын бут сөөг тарих" ажилд 23.0 сая төгрөг гэж ажил гэж баталсан байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 7.5-д "Аймаг, нийслэлийн жилийн төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 33.2-т заасныг дор дурдсан байдлаар тусгана:", 7.5.7-д "аймаг, нийслэлийн Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгана:

7.5.7.а/ төсвийн захирагчийн нэр;

7.5.7.б/ хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний нэр;

7.5.7.в/ байршил;

7.5.7.г/ хүчин чадал;

7.5.7.д/ хэрэгжүүлэх хугацаа;

7.5.7.е/ төсөвт өртөг;

7.5.7.ё/ санхүүжүүлэх эх үүсвэр;

7.5.7.ж/ тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүнг тусгана

гэсэн байхад гүйцэтгэгчийг нэр цохон баталж, улмаар худалдан авах ажиллагаанд бусад оролцогчийн эрхийг хязгаарласан байна.

БОХНСАХЗ-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 19 төсөл арга хэмжээ нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны үндсэн чиглэлд тусгагдсан байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/629 дугаар "Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" захирамжаар БОХНСАХЗ-аар 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ойн хортон мэрэгчтэй тэмцэх ажилд шууд худалдан авалт хийх журмыг мөрдөхөөр баталсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно" гэж заасныг зөрчсөн байна.

Г.2 Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг авч үзвэл 3 ажлыг нээлттэй төсөл сонгон шалгаруулалтаар, 2 ажлыг харьцуулалтын аргаар, 3 ажлын

худалдан авах, гэрээ байгуулах эрхийг сумдад шилжүүлж, 7 ажлыг шууд худалдан авалт хийсэн байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх 19 ажлын 5 ажил нээлттэй тендер шалгаруулалтаар, 2 ажил харьцуулалтын аргаар 3 ажил зөвлөх үйлчилгээний бага үнийн аргаар, 9 ажил шууд гэрээ байгуулах аргаар хийгдэхээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан.

Цөлжилтийг сааруулах ажлын хүрээнд бэлчээрийн хортонтой тэмцэх ажлыг тал хээрийн сумдын 50.0 мянган га-д зохион байгуулах ажилд 100.0 сая төгрөг батлагдсан. Тус ажлын худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдөр зарлаж, 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр нээх байсан боловч аймгийн ХХААГ-ын захиргаа аж ахуйн албаны даргаас албан бичиг ирж тендер шалгаруулалтыг зогсоож, аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/147 дугаар захирамжаар 14 суманд эрх шилжүүлсэн.

Мөн аймгийн Засаг даргын захирамжаар Сумдын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах /Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянцагаан, Баян, Алтанбулаг, Зуунмод/ болон Булаг шанд тохижуулах ажлыг /20 сум/ сумдад эрх шилжүүлсэн байна.

"Лүн сум дах сум дундын ойн ангид хариуцуулан, Зуунмод суманд хийгдэх "Ногоон паспорт-Ногоон төгөл" ойн зурвасыг өргөжүүлж, 1100 ширхэг навчит мод, гоёлын бут сөөг тарих" ажил гэж гүйцэтгэгчийг нэр зааж 23.0 сая төгрөгийн ажил батлагдсан. Тус ажилд хяналтын төсөвгүй тендер зарлаж Лүн сум дах сум дундын ой ангийг шалгаруулж гэрээ байгуулсан.

Г.3 БОХНСАХЗ-аар хэрэгжих 19 төсөл арга хэмжээнээс хөрөнгө оруулалтын чанартай 9 ажилд гэрээ байгуулснаас 7 ажил хугацаандаа бүрэн хэрэгжиж 2 ажил хугацаандаа хэрэгжээгүй байна.

Ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааг хийлгэж, 2021-2025 оны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах, Баянцагаан сумын 40 га-д тал хээрийн зарим сумыг цөлжилттэй тэмцэх чиглэлээр загвар сум болгож, хөрсний доройтлыг бууруулах, үржил шимийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээрийн олон наст ургамал тариалах ажлыг зохион байгуулах ажлууд нь хугацаандаа хэрэгжээгүй, гэрээний хугацааг сунгаагүй тул зөрчлийг таслан зогсоох, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага бичигдлээ.

Г.4 БОХНСАХЗ-аар хийгдэхээр төлөвлөсөн 19 төсөл арга хэмжээнээс 13 төсөл арга хэмжээ хэрэгжиж, 2 ажил хугацаандаа хэрэгжээгүй он дамжсан, дараах 4 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

БОХНСАХЗ-аар хийгдэхээр төлөвлөсөн дараах 4 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Тухайлбал:

- Хөндөгдсөн эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх ажлыг үргэлжлүүлэх, эзэнгүй орхигдсон талбайгаас 10га-д техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх ажлын худалдан авах ажиллагааг цахим системээр 4 удаа зарласан боловч оролцогч ирээгүй тул хэрэгжээгүй,

- Туул, Хэрлэн голуудын дагуу загас үржүүлэх, жимсний модны бут сөөг тарих үржүүлгийн газар байгуулах төслийн ТЭЗҮ-г мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх ажлын худалдан авах ажиллагааг цахим системээр 3 удаа зарласан боловч оролцогч ирээгүй тул хэрэгжээгүй,
- Хогийн үйлдвэр байгуулах зураг төсвийн ажилд инженер геологийн судалгаа хийлгэх шаардлага гарсан тул хэрэгжээгүй,
- Хараа, Ерөө голын сав газрын зөвлөлийн тавдугаар хуралдааныг зохион байгуулах ажил нь тус хуралдаан коронавирус-19 цар тахлын улмаас хэрэгжээгүй байна.

БОХНСАХЗ-аар санхүүжүүлэхээр төлөвлөгөөнд тусгагдаагүй “Зуунмод цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж, хашаа, гүүр байгууламжийн урсгал засварын ажил”-д 2.2 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/508 дугаар захирамжаар санхүүжүүлсэн байна.

Г.5 Он дамжин хэрэгжиж буй 68.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээнээс бусад хөрөнгө оруулалтын ажлуудыг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Аймаг, сумдын ОНХС, аймгийн төсвийн хөрөнгийн шилжих үлдэгдэл, Замын сан, Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар нийт 313 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсанаас 148 ажил бүрэн хэрэгжсэн байна.
- Аймгийн ОНХС, аймгийн төсвийн хөрөнгийн шилжих үлдэгдэл, Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх нийт 15 хөрөнгө оруулалтын ажил гэрээнд заасан хугацаандаа хэрэгжээгүй он дамжсан байна.
- ОНХС-г төлөвлөхөд сумдын хувьд иргэдийн санал авах ажил журмын дагуу хийгдэж, аймгийн ОНХС-г төлөвлөхөд журамд заасан иргэдийн саналыг тусгах ажил огт хийгдэхгүй байна.
- Аймаг сумд хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хугацааг баримтлахгүй байх, зарим Үнэлгээний хорооны үйл ажиллагаа холбогдох хууль, журамд нийцэхгүй байх зөрчлүүд давтан гарсаар байна.
- Тендер шалгаруулалтаар оролцогч санал ирүүлээгүй шууд гэрээ байгуулсан зарим ажлуудын хувьд техникийн тодорхойлолтод заасан шалгуурыг хангаагүй бараа /автомашин/ авах, шууд худалдан авалтын мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлдэггүй зэрэг зөрчил гарч байна
- Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжүүд хэрэгжихгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлд үндэслэн Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Д.Саран-Эрдэнэ нарт зөвлөх нь:

- Аймгийн түвшинд ОНХС-гийн үйл ажиллагааг төлөвлөхдөө Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлж, иргэд олон нийтийн оролцоог хангах талаар өгөгдсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх.
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заагдсан хугацааг баримтлан үнэлгээний хороодыг байгуулж, тендер шалгаруулалтыг хэрэгжүүлэх
- ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3-т “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэх заалтыг хэрэгжүүлэх, хяналт тавих

ОНӨГ-ын дарга Д.Батжаргалд зөвлөх нь:

- Үнэлгээний хороодын үйл ажиллагаанд тавих хяналтаа сайжруулж тендер шалгаруулалттай холбоотой илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар өмнөх аудитуудаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах
- Үнэлгээний хорооны маягтын бүрдэл, гарын үсэг, огноо баримт бичиг боловсруулалтад хяналт тавих

Тайлан хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор

Аудитын менежер

Ц.Хишигжаргал

О.Амаржаргал

Тайлан бичсэн:

Ахлах аудитор

Аудитор

Аудитор

Л.Жаргалсайхан

Ч.Загдсүрэн

Г.Сугармаа

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Тайлангийн төсөлд санал авах тухай албан бичгийг холбогдох 5 байгууллагад хүргүүлсэн. Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс албан бичгийн хариу ирүүлээгүй тул саналгүйд тооцсон.



41108 Зууныцаа, Төв хот
Утас: 30273539, Факс: 30273579

2021.06.21 № 177

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг" гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцаж ажиллав.

Аудитын тайланд тусгах нэмэлт санал байхгүй болно.

ДАРГА



Д. БАТЖАРГАЛ

202105089



ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

ТӨВ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Утас: 76122862, Факс: 76122182

2021.06.11 № 04/422
Тайлбар 2021.06.15 № 01/365

Тайлбар хүргүүлэх тухай

1. Аймгийн нийтийн номын сангийн их засварын ажлын захиалагчийн хяналтын талаар.

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас 2019.10.28-ны өдрийн ЗТ-03/19 тоот зураг төсөл боловсруулах даалгаврыг батлуулан 2019.12.19-нд зураг төслийг боловсруулах гэрээг Ди Эс Жи ХХК-тай байгуулан гүйцэтгүүлсэн. Аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 12-ны а/529 дүгээр захирамжаар БЗОСК-г захиалагчаар томилсон шийдвэр гарсан боловч, зураг төслийн ажлыг ГХБХБГазар хариуцан гүйцэтгүүлсэн тул ажлын тоо хэмжээг гарган 2020.04.16-ны 07/262 албан бичгээр ОНӨГ-т хүргүүлсэн. Төндөр шалгаруулалт, тодруулга авах явцад Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2020.05.05-ны 07/354 тоот албан бичигээр захиалагч БЗОСК-д хандах тухай мэдэгдсэн. Төндөрийн шалгаруулалт явагдаж дуусан гэрээг байгуулах шатанд Аймгийн Засаг даргын 2020.06.04-ны өдрийн а/343 тоот захирамжаар ГХБХБ-ыг захиалагчаар томилсон тул 2020.06.09-ний өдрийн 03/2020 тоот гэрээг байгуулсан.

2. Аймгийн нийтийн номын сангийн их засварын нэмэлт гэрээний талаар.

Аймгийн нийтийн номын сангийн их засварын ажлын үндсэн гэрээг 2020.06.09-ний өдөр 1145,8 сая төгрөгөөр байгуулсан. БНСУ-ын талын хөрөнгө оруулалтаар хийх ажлын ханшийн зөрүүнээс гарсан зардлаас аймгийн Засаг даргын 2020.12.01-ний а/592 захирамжаар 43,6 сая төгрөгөөр гэрлэн хаяг, Пентаек мужийн нэрэмжит өрөө тохижилт, фасадны гэрэлтүүлэгийн ажилд нэмэлт гэрээг байгуулсан. Орон нутгийн оролцоо 225,8 сая төгрөг санхүүжигдсэн. Пентаек мужийн өрөөний тохижилт, фасадны гэрэлтүүлэгийн ажлыг аймгийн Засаг даргын 2020 оны 12 сарын 01-ний өдрийн захирамжийн дагуу 2020 оны 12 сарын 07-ны өдөр 43,6 сая төгрөгийн 12/2020 дугаартай гэрээг аймгийн Нийтийн номын сангийн гүйцэтгэгч "Нумт өргөө" ХХК-тай байгуулсан. Тус ажил бүрэн дуусаагүй, гүйцэтгэгч талаас гүйцэтгэл гаргаж өгөөгүй тул санхүүжилт хийгдээгүй байна.

2021.06.11

М.З.Б. Төх. 5/1

3. Ашиглагч эзэмшигч байгууллагыг тодорхой болгож, данс бүртгэлд тусгуулах талаар.

-Газрын дуудлага худалдаагаар зарагдсан газруудад дэд бүтэц цахилгаан хангамжийн ажлын гүйцэтгэлийн бичиг баримтыг хөрөнгө бүртгэлдээ тусган авах талаар Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ны захиргаа, Зуунмод түгээх төвүүдэд 2020.10.28-ны 07/887, мөн өдрийн 07/888 тоот албан бичгээр хүргүүлсэн.

-Аймгийн Нийтийн номын сангийн их засварын ажил 2021.05.07-нд хүлээлгэн өгсөн. Нэмэлт гэрээний санхүүжилтийг олгож дуусаны дараа гүйцэтгэлийн баримт бичгийг хүлээлгэн өгөхөөр бэлтгэж байна.

46, 47, 48 байр хайрган хучилт, тэмдэг тэмдэглэгээ бүрэн хийлгэх ажлын үлдэгдэл ажлыг энэ оны 4 дүгээр сард авто замын бордюр, тэмдэг тэмдэглэгээний ажлыг хийж гүйцэтгэсэн. Ашиглагч байгууллагад гүйцэтгэлийн бичиг баримтыг хүлээлгэн өгөхөөр бэлтгэж байна.

4. Одонт хөтлийн гадна цахилгаан, нэмэлт ажлын талаар:

Аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Одонт хөтлийн цахилгааны ажил 15,0 сая төгрөг, Одонт хөтлийн нэмэлт ажилд 11,3 сая төгрөг батлагдсан. Гүйцэтгэгч нартай гэрээ байгуулан 2020 оны 04 дүгээр сард санхүүжилтийг олгосон. 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 3 дугаар тогтоолоор Одонт хөтлийн цахилгаан ажилд 16,8 сая, Одонт нэмэлт ажилд 9,5 төгрөг болгон баталсан гэсэн байна.

-Одонт хөтлийн бүтээн бэйгуулалтын ажлуудтай холбогдуулан гадна цахилгаан хангамжийн ажлын хөрөнгө 2019 онд тусгагдаагүй байсан тул Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ Зуунмод түгээх төвтэй гэрээ байгуулан 2019 онын 11 дүгээр сард гүйцэтгүүлж, санхүүжилтийг аймгийн Засаг даргын 2020.03.04-ний а/138 дугаар захирамжаар 15.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн.

-Одонт хөтлийн нэмэлт ажилд 11.3 сая төгрөгийн ажлыг 2019 онд хийлгүүлж, санхүүжилтийг өймгийн Засаг даргын 2020.03.04-ний а/138 дугаар захирамжаар 11.3 сая төгрөгийг санхүүжүүлсэн.

ДАРГА  М. ОТГОНБАТ

My dog likes it.

Тайлбар 1-г үзнэ үү.



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГИЙН
ГАЗАР


ХТ9001, Хөдөөмөд-10/4 Төв аймаг
Утас: 7607-3025 Факс: 7607-2215

2021.06.28 № 05/261
Тамгай _____ Өмг. № _____

ТӨРИЙН АУДИТЫН ТӨВ
АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАРТ

2020 оны Орон нутгийн хөгжлийн
сангийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүн,
дүгнэлттэй танилцан,

Аудитаар өсөлдсөн зөвлөмжийг
хэрэгжүүлэн ажиллах болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Ю.БЯМБАЦОГТ

4121020767



ТӨВ АЙМГИЙН
БАРИЛГА ЗАХИАЛАГЧ ОРОН
СҮҮЦНЭЙ КОРПОРАЦИ ОНЛААТУГ

41001 Дүүргийн Төв аймаг
Утас 30272618

2021.06.23 № 287
Төрийн _____ Төв № _____ -1

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу "Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг" гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцаллаа.
Холбогдох санал байхгүй болно.

ЗАХИРАЛ

Ж.БАТТӨГС

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

1. ГХБХБГ-ын 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 07/422 тоот албан бичигт тайланд тусгах санал биш, 4 тайлбар ирүүлсэн тул тайланд өөрчлөлт оруулах боломжгүй байна.

